



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2009 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах,
түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Тогтоол батлагдсантай холбогдуулан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих журам” батлах тухай Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 23 дугаар тогтоолыг энэ тогтоолын 1-д заасан журам үйлчилж эхэлмэгц хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих журам”-ын 2.1.3-т заасан учирч болзошгүй хохирлын нөөц сангийн эцсийн үлдэгдлийн 50 хувийг тусгайлсан нөөцөнд байршуулж, үлдсэн нөөцийн 60 хувийг энэ тогтоолын 1-д заасан журмын 2.1.2-т заасан “учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан”-гийн эхний үлдэгдлээр, 40 хувийг 2.1.4-т заасан “учирч болзошгүй хохирлын нөөц сан”-гийн эхний үлдэгдлээр тус тус тооцож, тусгайлсан нөөцийг 2 жилийн хугацаанд арилжааны банкны тусгай дансанд байршуулахыг даатгалын компаниудад үүрэг болгосугай. [Энэ зүйлд Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 03 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Даатгалын тухай хуулийн 14.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Энэхүү журмаар ердийн даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-ийн даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохицуулна.

Хоёр.Даатгалын нөөц сан

2.1. Даатгагч нь дараах нөөц сангуудыг даатгалын төрөл ба хэлбэр тус бүрээр байгуулна:

2.1.1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан;

2.1.2. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан;

2.1.3. Нэхэмжилсэн хохирлын нөөц сан;

2.1.4. Учирч болзошгүй хохирлын нөөц сан.

2.2. Заавал даатгалын нөөц санг санхүүгийн тайланд тусгайлан бүртгэнэ.

Гурав.Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

3.1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан ньдаатгуулагчид ирээдүйд төлөх нөхөн төлбөрийн нөөцийн хэсэг бөгөөд даатгагчийн үйл ажиллагааны зардал үүнд орсон байна.

3.2. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг даатгагчийн хүлээн авсан даатгалын хураамжаас гэрээний үлдэх хугацаанд ногдуулан байгуулна.

3.3. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг энэ журмын 3.8-д зааснаас бусад тохиолдолд 8-тын аргаар тооцох бөгөөд улирлын даатгалын цэвэр хураамжийн орлогоос дараах байдлаар тооцно:

$$3.3.1. \text{ОТХ} = \text{ОТХ}_1 + \text{ОТХ}_{.1} + \text{ОТХ}_{.2} + \text{ОТХ}_{.3}$$

$$3.3.2. \text{ОТХ}_1 = \text{ЦХ}_1 * 7/8$$

$$3.3.3. \text{ОТХ}_{.1} = \text{ЦХ}_{.1} * 5/8$$

3.3.1. $ОТХ_{.2}=ЦХ_{.2} * 3/8$

3.3.5. $ОТХ_{.3}=ЦХ_{.3} * 1/8$

3.4. Энэ журмын 3.3-т заасан товчлолыг дараах агуулга бүхий тайлбараар тодорхойлж ойлгоно.

3.4.1. ОТХ- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан;

3.4.2. $ОТХ_1$ - Тайлант улирлын орлогод тооцоогүй хураамж;

3.4.3. $ОТХ_{.1}$ - Тайлант улирлын өмнөх улирлын орлогод тооцоогүй хураамж;

3.4.4. $ОТХ_{.2}$ - Тайлант улирлаас 2 улирлын өмнөх орлогод тооцоогүй хураамж;

3.4.5. $ОТХ_{.3}$ - Тайлант улирлаас 3 улирлын өмнөх орлогод тооцоогүй хураамж;

3.4.6. $ЦХ_1$ - Тайлант улирлын цэвэр хураамжийн орлого;

3.4.7. $ЦХ_{.1}$ - Тайлант улирлын өмнөх улирлын цэвэр хураамжийн орлого;

3.4.8. $ЦХ_{.2}$ - Тайлант улирлаас 2 улирлын өмнөх цэвэр хураамжийн орлого;

3.4.9. $ЦХ_{.3}$ - Тайлант улирлаас 3 улирлын өмнөх цэвэр хураамжийн орлого.

3.5. Даатгалын нийт хураамжийн орлогоос давхар даатгалын хураамж, буцаасан даатгалын хураамжийг хасч даатгалын цэвэр хураамжийг тодорхойлно.

3.6. Давхар даатгалын хураамжийг даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дотоод, гадаадын өөр даатгагчид дахин даатгаж төлсөн болон төлөхөөр тооцсон дүнгээр тодорхойлно.

3.7. Буцаасан даатгалын хураамжийг хууль тогтоомжийн дагуу даатгалын гэрээний хугацаа дуусахаас өмнө даатгагчаас даатгуулагчид тухайн гэрээний үлдэх хугацаанд ногдуулан буцаан олгосон хураамжаар тодорхойлно.

3.8. Даатгалын гэрээг 1 жилээс өөр хугацаатай байгуулсан тохиолдолд даатгагч орлогод тооцоогүй хураамжийг тооцохдоо хувь тэнцүүлэх аргыг хэрэглэнэ.

3.9. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангаас тухайн тайлант хугацаанд ногдох хэсгийг орлогод тооцсон хураамж руу шилжүүлнэ.

3.10. Даатгалын гэрээний хураамжийг хэсэгчлэн төлж байгаа үед даатгалын хураамжийн эхний хэсэг орж ирэхэд даатгагч орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг байгуулах бөгөөд хэрэв даатгалын дараагийн хураамж тасалдвал орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг тасалдсан дүнгээр хорогдуулна.

Дөрөв.Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан

4.1. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлант хугацаанд нэхэмжилж болзошгүй хохиролд зориулан байгуулсан нөөц санг ойлгоно.

4.2. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц санг даатгалын тохиолдол нь тайлант улирлаас өмнөх үед учирсан бөгөөд тайлант улиралд нэхэмжилж болзошгүй нөхөн төлбөрийг барагдуулахад зориулан байгуулна. Уг нөөц санг өмнөх хугацааны даатгалын нөхөн төлбөрийн бодит мэдээлэлд үндэслэн актуар тооцоолор тооцож, орлогод тооцсон хураамжаас улирал бүр байгуулна;[Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 348 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

4.3. Тайлант улирлаас өмнө гарсан даатгалын тохиолдлын улмаас гэрээний дагуу даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд даатгуулагчийн нэхэмжилсэн дүнгээр уг нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан руу шилжүүлнэ. [Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 348 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

4.4. Даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлэх тохиолдолд төлүүлсэн дүнгээр уг нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлнэ.

4.5. Даатгалын тохиолдлын улмаас даатгуулагчийн даатгуулсан хөрөнгө бүрэн сүйрч улмаар даатгагч даатгуулсан хөрөнгийг өөрийн эзэмшил, өмчлөлд авсан тохиолдолд даатгагч уг хөрөнгийг учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангийн хөрөнгөнд бүртгэн авна.

Тав.Нэхэмжилсэн хохирлын нөөц сан

5.1. Нэхэмжилсэн хохирлын нөөц сан гэдэгт даатгуулагчийн нэхэмжилсэн хохирлыг нөхөн төлөхөд зориулагдсан нөөц санг ойлгоно.

5.2. Нэхэмжилсэн хохирлын нөөц санг даатгуулагчаас даатгалын нэхэмжлэл ирсэн тохиолдолд даатгуулагчийн нэхэмжилсэн дүнгээр учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан эсвэл орлогод тооцсон хураамжийг хорогдуулж байгуулна.

5.3. Тайлант улиралд гарсан даатгалын тохиолдлын дагуу даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулна. [Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 348 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

5.3. Даатгуулагчид олгох даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжилсэн хохирлын нөөц сангаас гаргана.

5.4. Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр нэхэмжилсэн хохирлын нөөц сангаас бага байвал зөрүүг нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулсан эх үүсвэр лүү буцаан шилжүүлнэ.

5.4.Тайлант улирлаас өмнө гарсан даатгалын тохиолдлын улмаас даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулна./[Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 348 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/](#)

Зургаа.Учирч болзошгүй хохирлын нөөц сан

6.1. Учирч болзошгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.

6.2. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд учирч болзошгүй хохирлын нөөцийн санг дараах аргачлалаар улирал тутамд байгуулна. Үүнд:

$$\left(\frac{\text{ОТХ} - \text{аас олгосон нөхөн төлбөр} + \text{байгуулсан УБНХНС}}{\text{ОТХ}} \right) * 100\% < X$$

үед

$$\text{УБНХНС} = \left[X - \left(\frac{\text{ОТХ} - \text{аас олгосон нөхөн төлбөр} + \text{байгуулсан УБНХНС}}{\text{ОТХ}} \right) * 100\% \right] \times \text{ОТХ}$$

Энд,

“ОТХ” – орлогод тооцсон хураамж;

“УБНХНС”- учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан;

“УБХНС” –учирч болзошгүй хохирлын нөөц сан;

“Х” – Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан

“Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын 3.1.1-д заасан

“Даатгалын цэвэр хураамж”-ийн хувь. /[Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 389 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

Хэлбэр тус бүрийн хувьд даатгуулагчид олгохоор тооцоолсон нөхөн төлбөр нь орлогод тооцоогүй хураамжаас их байх тохиолдолд тэр зөрүүгээр учирч болзошгүй хохирлын нөөц санг орлогод тооцсон хураамжаас байгуулна.

6.3. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан болон орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулахад хүрэлцэхгүй болсон

тохиолдолд дутсан хэсгийг учирч болзошгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан руу шилжүүлнэ.

6.3¹. Даатгалын цэвэр хураамжийн хувийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр тооцож Хороонд ирүүлнэ. Хороо даатгалын цэвэр хураамжийн хувийг тооцож ирүүлснээс хойш 30 хоногийн дотор багтаан хянаж, хариу хүргүүлнэ. Албан журмын даатгалын хувьд цэвэр хураамжийн хувийг Хороо жил бүр тогтооно. [Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 389 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

6.4. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан нь нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд учирч болзошгүй хохирлын нөөц сангаас дутагдсан хэсгийг бүрдүүлэх ба хэрэв учирч болзошгүй хохирлын нөөц сан хүрэлцэхгүй болсон тохиолдолд орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан луу шилжүүлнэ.

6.5 Орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэхэд хүрэлцэхгүй болсон тохиолдолд дутагдсан хэсгийг учирч болзошгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан луу шилжүүлнэ.

6.6. Энэ журмын 6.4, 6.5-д заасны дагуу нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хороонд мэдэгдэнэ.

Долоо.Даатгалын нөөц санд тавих хяналт

7.1. Даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд даатгалын бүх нөхөн төлбөр, хураамжийн буцаалт хийгдсэний дараах нөөц сангийн үлдэгдлээс Хорооноос томилсон актуарчдын актуар тооцооллын дагуу тохирох хэсгийг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Даатгагчдын холбооны тусгайлсан дансанд байршуулна.

7.2. Энэ журмын 7.1-д заасан тусгайлсан дансанд нөөц сангийн мөнгийг 5 жилийн хугацаанд байршуулж, зөвхөн даатгалын нөхөн төлбөрт зарцуулах ба хэрэгжилтэнд Хороо байнгын хяналт тавина.

7.3. Даатгалын нөөц сангийн хөрөнгийг зөвхөн тухайн сангийн зориулалтын дагуу зарцуулах бөгөөд хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно.

7.4. Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд Хорооулирал тутам хяналт тавина.

7.5. Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг Хорооноос зөвшөөрсөн маягтуудын дагуу гаргаж, улирал бүр Хороонд ирүүлнэ.

7.6. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.